



ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН
ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2017 оны 11 сарын 22 өдөр

Дугаар А/196

Улаанбаатар хот

Сургалт зохион байгуулах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.5 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2016 оны А/203 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтын 3.2.2, 4.7.6, 7.4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Стратеги төлөвлөлт ба хяналт шинжилгээ үнэлгээ сэдэвт удирдах ажилтанд зориулсан сургалт", "Эмийн сангийн бүртгэл мэдээлэл, аж ахуй нэгжийн орлого, зарлагын тайлагнах үйл ажиллагааны чанарыг сайжруулах" сургалтуудын удирдамж, хөтөлбөрийг нэгдүгээр, төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Сургалт зохион байгуулахад шаардагдах төсвийг хичээл үйлдвэрлэлийн дадлагын зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч /Д.Гантуяа/-д зөвшөөрсүгэй.
3. Сургалтыг удирдамжийн дагуу чанартай зохион байгуулахыг Бодлогын судалгаа, удирдлагын сургалтын алба /Д.Баттулга/-д үүрэг болгосугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүү-үйлчилгээний алба /Л.Оюунчимэг/-д даалгасугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Б.НАРАНТУЯА



Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Ерөнхий захирлын
2017 оны 11 дугаар сарын 17 өдрийн 11 дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт

СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨЛТ БА ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ
СЭДЭВТ УДИРДАХ АЖИЛТАНД ЗОРИУЛСАН СУРГАЛТЫН УДИРДАМЖ

Хэзээ:	2017 оны 11 сарын 17
Сургалтын хугацаа:	09.00-17.00 цагт 1 өдрийн сургалт
Зохион байгуулах газар:	Удирдлагын академийн 110 тоот сургалтын танхим
Зохион байгуулагч:	Эрүүл мэндийн хөгжлийн төв
Сургалтын зохицуулагч:	Б. Ганчулуун /БСУСА-ны мэргэжилтэн/
Сургагч, чиглүүлэгч:	Удирдлагын академийн багш Т.Түмэнцогтоо, Н. Болд
Оролцогчид:	ЭМЯ харьяа 16 эмнэлгийн стратеги төлөвлөлт хариуцсан алба, хэлтсийн дарга, мэргэжилтэн 25 хүн

Зорилго: Эрүүл мэндийн байгууллагын удирдах ажилтны стратеги төлөвлөгөө боловсруулах, түүний хэрэгжилтийг хангахад хяналт шинжилгээ үнэлгээний арга зүйн ур чадварыг эзэмшүүлэх.

Сургалтын гол зорилтууд :

- Эрүүл мэндийн байгууллагын стратеги төлөвлөлт хийх ур чадварыг практик амьдралд ашиглаж сурах.
- Бодлого, хөтөлбөр, төсөл үйл ажиллагаанд үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээг нэвтрүүлэх арга зүй эзэмшихэд дэмжлэг үзүүлэх.

Хүлээгдэж буй үр дүн:

Энэхүү 1 өдрийн сургалтын төгсгөлд оролцогчид дараах мэдлэг, чадварыг эзэмшсэн байна:

- Эрүүл мэндийн байгууллагын стратегийн төлөвлөгөө боловсруулах, түүний хэрэгжилтийг төлөвлөх мэдлэг чадвар эзэмшинэ.
- Үр дүнд суурилсан хяналт шинжилгээ, үнэлгээг байгууллагын түвшинд ашиглах чадвар эзэмшинэ.

Агуулга:

- Байгууллагын эрхэм зорилго, зорилго, зорилтыг тодорхойлох арга зүй
- Стратеги хувилбар, сонголт хийх арга зүй
- Стратегийн хэрэгжилтийг төлөвлөх арга зүй
- Хяналт шинжилгээ, үнэлгээ үр дүнд суурилсан хяналт шинжилгээ, үнэлгээний талаарх ойлголт
- Үр дүнд суурилсан хяналт шинжилгээ, үнэлгээний онцлог, үндсэн элементүүд
- Үр дүнд суурилсан хяналт шинжилгээ, үнэлгээний тогтоцлоо бий болгох, ашиглах нь

Арга зүй:

- Танилцуулга ба гарын авлага
- Бүлгийн болон нэгдсэн хэлэлцүүлэг
- Бүлгийн ажил (дасгал, кейс, бодит амьдралын жишээ, арга хэрэгслүүд)

**СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨЛТ БА ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ
СЭДЭВТ УДИРДАХ АЖИЛТАНД ЗОРИУЛСАН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР**

Хугацаа	Агуулга	Багш, илтгэгч, чиглүүлэгч
Хичээлийн хуваарь		
08.30-09.00	Бүртгэл	Б.Ганчулуун сургалтын зохицуулагч
09.00-09.10	Нээлтийн үйл ажиллагаа	ЭМХТ-н Ерөнхий захирал
09.10-09.15	Танилцуулга, нүүр хагарах	Б.Ганчулуун сургалтын зохицуулагч
09.15-09.35	Байгууллагын эрхэм зорилго, зорилго, зорилтыг тодорхойлох арга зүй	Т.Түмэнцогтоо Удирдлагын академийн багш
09.35-10.00	Бүлгийн ажил	Б.Ганчулуун сургалтын зохицуулагч
10.00-10.20	Цайны завсарлага	
10.20-10.40	Стратеги хувилбар, сонголт хийх арга зүй	Т.Түмэнцогтоо Удирдлагын академийн багш
10.40-11.00	Бүлгийн ажил	Б.Ганчулуун сургалтын зохицуулагч
11.40-12.00	Стратегийн хэрэгжилтийг төлөвлөх арга зүй	Т.Түмэнцогтоо Удирдлагын академийн багш
12.00-12.20	Бүлгийн нэгдсэн хэлэлцүүлэг	Б.Ганчулуун сургалтын зохицуулагч
12.30-13.30	Үдийн хоол	
13.30-14.00	Бүлгийн ажлын танилцуулга	Б.Ганчулуун сургалтын зохицуулагч
14.00-14.20	Хяналт шинжилгээ, үнэлгээ үр дүнд суурилсан хяналт шинжилгээ, үнэлгээний талаарх ойлголт	Н. Болд Удирдлагын академийн багш
14.20-14.40	Бүлгийн ажил	Б.Ганчулуун сургалтын зохицуулагч
14.40-15.00	Үр дүнд суурилсан хяналт шинжилгээ, үнэлгээний онцлог, үндсэн элементүүд	Н. Болд Удирдлагын академийн багш
15.00-15.20	Цайны завсарлага	
15.20-15.40	Бүлгийн ажил	Б.Ганчулуун сургалтын зохицуулагч
15.40-16.00	Үр дүнд суурилсан хяналт шинжилгээ, үнэлгээний тогтоцлоо бий болгох, ашиглах нь	Н. Болд Удирдлагын академийн багш
16.00-16.20	Бүлгийн нэгдсэн хэлэлцүүлэг	Б.Ганчулуун сургалтын зохицуулагч
16.20-16.40	Бүлгийн ажлын танилцуулга	Б.Ганчулуун сургалтын зохицуулагч
16.40-17.00	Дуусах	

"ЭМИЙН САНГИЙН БҮРТГЭЛ МЭДЭЭЛЭЛ, АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГО, ЗАРЛАГЫН ТАЙЛАГНАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧАНАРЫГ САЙЖРУУЛАХ" СУРГАЛТЫН УДИРДАМЖ

Үндэслэл:

Монгол Улсын "Статистикийн тухай хууль", Үндэсний Статистикийн хорооны даргын 2013 оны 1/150 дугаар тушаал, эрүүл мэндийн статистик мэдээ, тайлангийн талаар Эрүүл мэндийн сайдын тушаал, журмын хэрэгжилтийг хангах нь Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний өртөг тооцох, нийслэлийн хэмжээний хүн амын эрүүл мэндийн үзүүлэлтийг үнэн зөв тооцоолох чухал ач холбогдолтой.

Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага, аж ахуйн нэгжийн орлого, зарлагын тайланг 2005 оноос хойш өнөөг хүртэл цаасан хэлбэрээр хүлээн авч, нэгтгэж байна. Мөн хүний нөөц, хүчин чадлын тайланг цаасан хэлбэрээр авч, нэгтгэлийг хийж байна. Дээрх тайлагнах үйл ажиллагааг цахимжуулах шаардлагыг холбогдох байгууллагад тавьснаар 2018 оноос цахимжуулах ажлыг хийх гэж байгаатай холбоотой тайланг үнэн зөв тооцоолон гаргах аргачлал, мэдлэгийг олгох шаардлагатай байна.

Зорилго:

Хувийн хэвшлийн эмийн сангийн мэдээ, тайлан хариуцсан ажилтанд эрүүл мэндийн статистикийн болон орлого, зарлагын мэдээ, тайлан гаргах арга, аргачлалд сургах.

Зорилт:

1. Эрүүл мэндийн статистик, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой бодлогын баримт бичиг, хууль эрх зүйн орчны талаар мэдээлэл өгөх,
2. Эмийн сангийн улирал, жилийн эцсийн тайлан гаргах арга, аргачлалыг танилцуулах,
3. Эрүүл мэндийн мэдээ, мэдээлэлд дүн шинжилгээ хийх чадавхийг бэхжүүлэх,
4. Цахим бүртгэлийн программ нэвтрүүлэхтэй холбоотой программын танилцуулга хийх.

Хамрах хүрээ:

Хувийн хэвшлийн эмийн сангийн мэдээ, тайлан хариуцсан 200 мэргэжилтэн

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

1. Сургалтын бэлтгэл үйл ажиллагааг хангах /хөтөлбөр боловсруулах, танилцуулга, илтгэл, зарыг түгээх, өрөөг бэлтгэх/,
2. Хувийн эмийн сангийн мэдээ ирүүлэлтийн байдалд сүүлийн 3 жилээр хийсэн үнэлгээний дүнг танилцуулах,

Гарах үр дүн:


1. Эрүүл мэндийн мэдээлэл, аж ахуйн нэгжийн орлого, зарлагыг тайлагнах, тусгай зөвшөөрлийн үйл ажиллагаатай холбоотой бодлогын баримт бичиг, тушаал шийдвэр танилцагдсан байна,
2. Эмийн сангийн улирал болон жилийн эцсийн тайлан, мэдээ гаргах арга аргачлалд суралцсан байна,
3. Эмийн сангийн мэдээ ирүүлэлтийн хамрагдалт нэмэгдэж, мэдээний чанар сайжирсан байна,
4. Эрүүл мэндийн мэдээ, мэдээлэлд дүн шинжилгээ хийх чадавхитай болсноор мэдээ, тайлангийн чанарт ахиц гарсан байна.

“ЭМИЙН САНГИЙН БҮРТГЭЛ МЭДЭЭЛЭЛ, АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГО, ЗАРЛАГЫН ТАЙЛАГНАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧАНАРЫГ САЙЖРУУЛАХ” ХӨТӨЛБӨР

2017.11.08, 09-ны өдөр

Хугацаа	Сэдэв	Чиглүүлэгч багш
08.30- 09.00	Оролцогчдыг бүртгэх	Сургалт зохион байгуулагч
09.00-09.15	Нээлтийн үйл ажиллагаа	Сургалт зохион байгуулагч
09.15-09.30	Эрүүл мэндийн статистикийн талаар баримталж буй бодлогын баримт бичиг, хууль эрх зүйн орчин	С.Ариунтуяа, НЭМГ-ын СМХ-ийн дарга
09.30-10.10	Орлого зарлагын тайлан, үндэсний тооцоололд ашиглах нь ЭМТ201.27.2 маягтаар мэдээ гаргах, тайланг цахимжуулах асуудал	Т.Өнөрцэцэг /ЭМҮТ хариуцсан ахлах мэргэжилтэн/
10.10-10.30	Цайны завсарлага	
10.30-11.10	Орлого зарлагын тайлан гаргах арга, аргачлал	Б.Доржмягмар
11.10-11.40	Эм зүйн салбарт мөрдөгдөж буй хууль эрх зүйн орчин, эмийн сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй холбоотой мэдээлэл	Д.Болдбаатар
11.40-12.00	Жилийн эцсийн хүчин чадал, хүний нөөцийн тайлан гаргах талаар мэдээлэл өгөх	Г.Дэлгэрсүрэн
12.00-12.20	Эмийн сангийн улирлын мэдээ ирүүлэлтийн байдалд хийсэн үнэлгээний дүнг танилцуулах	Б.Сэргэлэн

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Ерөнхий захирлын
2011 оны 11 дугаар сарын 22 өдрийн 119 дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт



СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨЛТ БА ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ
СЭДЭВТ УДИРДАХ АЖИЛТАНД ЗОРИУЛСАН СУРГАЛТЫН ТӨСӨВ

№	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ	Оролцогчийн тоо	Нийт
1	Сургалтын төлбөр	цаг	8	5,500	44,000	25	1,100,000
2	Кофе цай	удаа	2	2,000	4,000	25	100,000
3	Бичиг хэрэгсэл	ш	1	4,000	4,000	25	100,000
	Нийт дүн						1,300,000

"ЭМИЙН САНГИЙН БҮРТГЭЛ МЭДЭЭЛЭЛ, АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГО, ЗАРЛАГЫН
ТАЙЛАГНАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧАНАРЫГ САЙЖРУУЛАХ" СУРГАЛТЫН ТӨСӨВ

№	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт
1	Цайны зардал	2өдөр*3удаа	100 хүн	850	510,000
2	Бичиг хэргийн зардал (самбарын үзэг, бичгийн цаас, ханын цаас)	Ширхэг	20	5,000	100,000
3	Сургалтын материал бэлтгэх, хувилах зардал	Ширхэг	400	100	40,000
4	Бусад зардал				50,000
	Нийт дүн				700,000